



**ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 10

Өмнөдэлгэр сум

Гурванбаян тосгоны Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Тавдугаар Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Гурванбаян тосгоны Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хяналтын хорооны дарга:	Р.Цогхүү	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
Нарийн бичгийн дарга:	Б.Жаргалсайхан	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ганчимэг	Хүнс хөдөө аж ахуйн газрын Хоршоо, жижиг дунд, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Оюунцэцэг	Санхүү албаны дарга
	Д.Алтансүвд	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Хяналтын хороо нь журмын дагуу хяналт тавин тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг хяналтын хорооны дарга (Р.Цогхүү)-д даалгасугай.

D.disc /alban bichig/ ИТН тогтоол

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг Хяналтын хороо болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ